

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо : 2025 оны 08 дугаар сарын 06

Сонгон шалгаруулалтын нэр: **Бага агуулгатай төмрийн хүдрийг боловсруулах ажил гүйцэтгэж, бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах**

“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ нь эрх бүхий оролцогчдоос **Бага агуулгатай төмрийн хүдрийг боловсруулах ажлыг** бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран гүйцэтгэх тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

Сонгон шалгаруулалтын баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50000** төгрөгөөр худалдан авна.

Оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **сүүлийн 2 жил буюу 2023, 2024 онуудын** аль нэг жилийн борлуулалтын орлого нь **50 сая төгрөгөөс багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **50 сая төгрөгөөс багагүй байх**

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **сүүлийн 2 жил буюу 2023 он, 2024 он**

Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: **2 жилээс доошгүй**

Ижил төстэй ажил гэдэгт төмрийн хүдрийн баяжуулалт, боловсруулалтын чиглэлээр ажиллаж байсан гэж ойлгоно. Гэрээгээр ажилласан бол гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, тодорхойлолт зэргийг ирүүлэх шаардлагатай.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **үгүй**

Саналыг 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба сонгон шалгаруулалтыг 2025 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 09 цаг 05 минутад “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын 301 тоот уулзалтын өрөөнд нээнэ.

Гадаадын хуулийн этгээд санал ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Эрхгүй

Улаанбаатар хот 51, ш/х – 002
Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө. 22-р хороо,
“Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ийн байр, 301 тоот өрөө,
И-мейл: mailbox@monros.mn.
Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-450060-175,